



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/122/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Мандалговь хот 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: batsaikhant@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.1 Залруулсан алдаа	14
4.3 Албан шаардлага	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө

1. Аудитын санал дүгнэлт



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
48090 Дундговь аймаг, Сайнцагаан сум
Утас: 70592439, 70592208, 70593208
И-мэйл: dundgovi@audit.gov.mn

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ё.САЙХАНТУЯА ТАНАА**

2022.02.18 № 10

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

0012020688

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	50,808,717.50	56,867,232.00
35	БАРАА МАТЕРИАЛ	50,062,717.50	56,867,232.00
351	Түүхий эд материал	40,000.00	40,000.00
35110	Тусгай зориулалттай материал	40,000.00	40,000.00
354	Хангамжийн материал	50,022,717.50	56,827,232.00
35410	Бичиг хэргийн материал	931,575.00	1,166,575.00
35420	Аж ахуйн материал	44,951,107.00	54,325,757.00
35440	Түлш, шатах тослох материал	3,780,035.50	974,900.00
35450	Барилгын засварын материал	360,000.00	360,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	606,285,601.09	817,552,504.75
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	606,285,601.09	817,552,504.75
392	Биет хөрөнгө	592,198,733.72	793,542,504.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	610,491,594.73	579,233,650.16
39202	Хуримтлагдсан элэгдэл	(219,593,374.47)	(171,319,928.70)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	74,094,800.00	246,794,007.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(16,149,166.62)	(19,279,547.67)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	149,714,821.00	195,919,841.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40,406,799.87)	(67,610,093.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,003,724.00	34,524,617.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,659,370.05)	(10,422,545.21)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	5,702,505.00	5,702,505.00
393	Биет бус хөрөнгө	14,086,867.37	24,010,000.00
39301	Програм хангамж	1,210,000.00	10,210,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,073,132.63)	(150,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	13,950,000.00	13,950,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	657,094,318.59	874,419,736.75
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	657,094,318.59	874,419,736.75
51	Засгийн газрын хувь оролцоо	657,094,318.59	874,419,736.75
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	469,902,823.77	469,902,823.77
51101	Өмч: - төрийн	469,902,823.77	469,902,823.77
512	Хуримтлагдсан үр дүн	19,984,441.80	237,309,859.96
51210	Өмнөх үеийн үр дүн	19,984,441.80	19,984,441.80
51220	Тайлант үеийн үр дүн	-	217,325,418.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	167,207,053.02	167,207,053.02
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	657,094,318.59	874,419,736.75

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	525,588,424.77	812,499,968.04
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	162,109,453.00	360,253,047.00
120	Нийтлэг татварын бус орлого	162,109,453.00	360,253,047.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	162,109,453.00	360,253,047.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	162,109,453.00	360,253,047.00

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	363,478,971.77	452,246,921.04
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,922,971.77	103,771,821.04
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	890,000.00	32,471,651.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,967,605.22	58,284,385.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,065,366.55	13,015,785.04
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	325,556,000.00	348,475,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	325,556,000.00	348,475,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	424,477,930.01	572,841,216.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	424,477,930.01	572,841,216.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	418,744,954.59	528,608,080.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	226,718,187.95	224,011,051.59
210101	Үндсэн цалин	185,329,356.75	167,309,941.65
210102	Нэмэгдэл	27,535,214.60	49,546,285.59
210104	Урамшуулал	6,515,943.60	7,154,824.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,308,793.39	29,214,497.02
210201	Тэтгэврийн даатгал	19,167,160.38	20,413,651.81
210202	Тэтгэмжийн даатгал	2,285,249.77	2,272,759.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,146,907.55	1,818,207.27
210204	Ажилгүйдлийн даатгал	424,497.77	428,952.71
210205	Эрүүл мэндийн даатгал	4,284,977.92	4,280,926.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,402,988.01	17,396,608.55
210301	Гэрэл, цахилгаан	2,671,870.99	3,664,135.40
210302	Түлш, халаалт	13,653,117.02	13,653,973.15
210303	Цэвэр, бохир ус	78,000.00	78,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,592,130.50	22,044,215.50
210401	Бичиг хэрэг	3,077,150.00	2,026,600.00
210402	Тээвэр, шатахуун	16,877,440.50	15,623,715.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,597,440.00	2,140,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	63,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,686,700.00	1,653,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,355,650.00	3,298,900.00
210604	Урсгал засвар	7,355,650.00	3,298,900.00
2107	Томилолт, зочны зардал	4,774,000.00	5,154,000.00
210702	Дотоод албан томилолт	4,774,000.00	5,154,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,568,811.00	24,005,510.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,108,972.00	22,912,075.00
210803	Даатгалын үйлчилгээ	418,800.00	419,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	242,060.00	121,436.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	410,000.00
210807	Газрын төлбөр	76,979.00	87,199.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	95,024,393.74	203,483,297.37

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,457,500.00	115,284,307.40
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	75,566,893.74	88,198,989.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,732,975.42	44,233,136.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,600,000.00	5,886,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	1,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	3,186,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,600,000.00	1,700,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,132,975.42	38,347,136.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,132,975.42	38,347,136.48
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>101,110,494.76</u>	<u>239,658,751.53</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,225,893.52	22,333,333.37
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	958,293.52	22,333,333.37
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(11,225,893.52)	(22,333,333.37)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>89,884,601.24</u>	<u>217,325,418.16</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/Төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>362,770,871.77</u>	<u>452,246,921.04</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	362,770,871.77	452,246,921.04
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,214,871.77	103,771,821.04
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	890,000.00	32,471,651.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,154,505.22	58,284,385.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,170,366.55	13,015,785.04
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	325,556,000.00	348,475,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	325,556,000.00	348,475,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>355,485,871.77</u>	<u>444,271,921.04</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	355,485,871.77	444,271,921.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	349,752,896.35	400,038,784.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	226,718,187.95	224,011,051.59
210101	Үндсэн цалин	185,329,356.75	167,309,941.65
210102	Нэмэгдэл	27,535,214.60	49,546,285.59
210104	Урамшуулал	6,515,943.60	7,154,824.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,308,793.39	29,214,497.02
210201	Тэтгэврийн даатгал	19,167,160.38	20,413,651.81
210202	Тэтгэмжийн даатгал	2,285,249.77	2,272,759.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,146,907.55	1,818,207.27

210204	Ажилгүйдлийн даатгал	424,497.77	428,952.71
210205	Эрүүл мэндийн даатгал	4,284,977.92	4,280,926.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,402,988.01	17,396,608.55
210301	Гэрэл, цахилгаан	2,671,870.99	3,664,135.40
210302	Түлш, халаалт	13,653,117.02	13,653,973.15
210303	Цэвэр, бохир ус	78,000.00	78,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,730,099.00	17,464,300.00
210401	Бичиг хэрэг	3,077,150.00	2,201,600.00
210402	Тээвэр, шатахуун	20,408,009.00	10,868,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,597,440.00	2,140,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	63,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,294,100.00	1,653,600.00
2105	Нормативт зардал	100,000.00	310,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	310,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,805,650.00	3,298,900.00
210604	Урсгал засвар	7,355,650.00	3,298,900.00
2107	Томилолт, зочны зардал	4,774,000.00	5,154,000.00
210702	Дотоод албан томилолт	4,774,000.00	5,154,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,860,711.00	24,005,510.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,400,872.00	22,912,075.00
210803	Даатгалын үйлчилгээ	418,800.00	419,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	242,060.00	121,436.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	410,000.00
210807	Газрын төлбөр	76,979.00	87,199.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,052,467.00	79,183,917.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,052,467.00	79,183,917.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,732,975.42	44,233,136.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,600,000.00	5,886,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	1,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	3,186,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,600,000.00	1,700,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,132,975.42	38,347,136.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,132,975.42	38,347,136.48
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>7,285,000.00</u>	<u>7,975,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,285,000.00	7,975,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,285,000.00	7,975,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,285,000.00	7,975,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,285,000.00	7,975,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(7,285,000.00)</u>	<u>(7,975,000.00)</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	469,902,823.77	167,207,053.02	-69,900,159.44	567,209,717.35
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	469,902,823.77	167,207,053.02	-69,900,159.44	567,209,717.35
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	89,884,601.24	89,884,601.24
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	469,902,823.77	167,207,053.02	19,984,441.80	657,094,318.59
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	469,902,823.77	167,207,053.02	19,984,441.80	657,094,318.59
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	469,902,823.77	167,207,053.02	19,984,441.80	657,094,318.59
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	217,325,418.16	217,325,418.16
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	469,902,823.77	167,207,053.02	237,309,859.96	874,419,736.75

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /			
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	348,475,100.00	327,999,620.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	348,475,100.00	327,999,620.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	343,289,100.00	322,813,620.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,014,400.00	224,011,051.59
210101	Үндсэн цалин	167,312,800.00	167,309,941.65
210102	Нэмэгдэл	49,546,400.00	49,546,285.59
210104	Урамшуулал	7,155,200.00	7,154,824.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,332,700.00	29,214,497.02
210201	Тэтгэврийн даатгал	20,452,600.00	20,413,651.81
210202	Тэтгэмжийн даатгал	2,281,800.00	2,272,759.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,825,600.00	1,818,207.27
210204	Ажилгүйдлийн даатгал	437,900.00	428,952.71
210205	Эрүүл мэндийн даатгал	4,334,800.00	4,280,926.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,515,900.00	15,501,137.10

210301	Гэрэл, цахилгаан	1,782,400.00	1,768,663.95
210302	Тулш, халаалт	13,655,000.00	13,653,973.15
210303	Цэвэр, бохир ус	78,500.00	78,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,716,500.00	14,716,500.00
210401	Бичиг хэрэг	1,648,600.00	1,648,600.00
210402	Тээвэр, шатахуун	10,248,800.00	10,248,800.00
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	1,495,000.00	1,495,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	724,100.00	724,100.00
2105	Нормативт зардал	310,000.00	310,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	310,000.00	310,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,673,300.00	8,647,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,000,000.00	7,975,000.00
210604	Урсгал засвар	20,673,300.00	672,800.00
2107	Томилолт, зочны зардал	5,414,100.00	5,154,000.00
210702	Дотоод албан томилолт	5,414,100.00	5,154,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,446,300.00	1,392,735.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	299,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	419,800.00	419,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	121,500.00	121,436.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	105,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	410,000.00	410,000.00
210807	Газрын төлбөр	90,000.00	87,199.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,865,900.00	23,865,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,865,900.00	23,865,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,186,000.00	5,186,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,186,000.00	5,186,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1,000,000.00	1,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,186,000.00	3,186,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	348,475,100.00	348,475,100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	348,475,100.00	348,475,100.00
122005	Орон нутгийн төсвөөс	348,475,100.00	348,475,100.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	20,475,479.29

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл / төгрөгөөр /
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	85,900,163.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	85,900,163.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	85,200,163.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,895,471.45
210301	Гэрэл, цахилгаан	1,895,471.45

2104	Хангамж, бараа материалын зардал	2,747,800.00
210401	Бичиг хэрэг	553,000.00
210402	Тээвэр, шатахуун	620,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	645,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	929,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,626,100.00
210604	Урсгал засвар	2,626,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,612,775.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,612,775.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,318,017.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,318,017.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	700,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,871,657.19
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	17,871,657.19
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	103,771,821.04
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,771,821.04
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	32,471,651.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,284,385.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,015,785.04

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Т.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 19-ний өдрийн 09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газар нь эрхэм зорилгоо “Хүмүүнлэг ардчилсан нийгмийн шаардлагад нийцсэн төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, шуурхай, чанартай хүргэж, төрийн албаны зорилт, чиг үүргийг үр ашигтай, үр нөлөөтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино ” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт, шалгалт хийгдсэн. Хяналт, шалгалтаар албан томилолтын журмыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөгдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын

үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 4 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 4 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 572,841.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,728.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,009.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 217,325.4 мянган төгрөгөөр буюу 34 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	746.0	-	(746.0)
Бараа материал	50,062.7	56,867.2	6,804.5
Үндсэн хөрөнгө	606,285.6	817,552.5	211,266.9
Нийт хөрөнгө	657,094.3	874,419.7	217,325.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	657,094.3	874,419.7	217,325.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	657,094.3	874,419.7	217,325.4

Бараа материал дансны үлдэгдэл 56,867.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,804.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 18,425.2 мянган төгрөгийн, хандив тусламжаар 41,860.0 мянган төгрөгийн нийт 60,285.2 мянган төгрөгийн аж ахуйн материалын өсөлт нөлөөлсөн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд хандиваар 313,494.2 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 7,975.0 мянган төгрөгийн, шилжүүлэн авсан 330.0 төгрөгийн хөрөнгийг зохих дансанд бүртгэж, 127,632.1 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас шилжүүлсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 874,419.7 мянган төгрөг болж 217,325.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 348,475.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 348,475.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг дээрх дүнгээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 348,475.1 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 348,475.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд нийт төсвийн 94.1 хувийг зарцуулж, 20,475.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 327,999.6 мянган төгрөг буюу 94.1 хувьтай байгаа нь Засаг даргын Тамгын газрын албан өрөөний урсгал засварын санхүүжилт тайланд оны сүүлээр орж ирсэн нь засвар хийх хугацаа бага, гүйцэтгэх хуулийн этгээдийг шалгаруулах боломжгүй байсан нь нөлөөж батлагдсан урсгал засварын зардлыг зарцуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 58,284.3 мянган төгрөг, ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж 32,471.7 мянган төгрөг төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 13,015.8 мянган төгрөг, нийт 103,771.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 2,747.8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 2,626.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 22,612.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 55,318.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 700.0 мянган төгрөг, байр ашиглалтын зардалд 1,895.4 нийт 85,900.2 мянган төгрөгийг зарцуулж, 17,871.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 79,999.2 мянган төгрөгийн, байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 36,000.0 мянган төгрөгийн, Улсын онцгой комиссын №297 тоот тогтоолоор олгосон 85,000.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгслүүд нэмэгдсэн байна. Уг хөрөнгүүдийн худалдан авах ажиллагааг дээд шатны байгууллага зохион байгуулан худалдан авч шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй тул гол асуудал байхгүй гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 20 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 онд нийт 334,341.5 мянган төгрөгийн 163 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулснаас 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар сумын төрийн сангийн мэргэжилтэнд ажлын байрны тодорхойлолтод заасан статистик мэдээллийн ажлыг гүйцэтгүүлсний ажил хавсарсны нэмэгдэл олгосон 1,263.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосны барагдуулаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан бараа материалын дансанд завсрын аудитаар хяналтын тооллого хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 47,100.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 523.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 46,576.7 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Завсрын аудитаар тээвэр шатахууны 523.7 мянган төгрөгийн зардлыг өглөгөөр тусгаагүйг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад нийт 523.7 мянган төгрөгийн залруулга хийсэн.

4.3 Албан шаардлага

Аудитаар илэрсэн дараах зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. 2021 оны жилийн завсрын аудитаар хяналтын тооллогоор 46,576.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө биетээр байхгүй дутагдсан.

Шийдвэрлэсэн нь: Хугацаатай албан шаардлага хүргүүлж 2021 оны 11 дүгээр сарын 11 өдрийн 325 тоот албан бичгээр хэрэгжилтийг ирүүлсэн. Завсрын аудитаар хүргүүлсэн албан шаардлагын хүрээнд хөрөнгийг хүлээн авч зөрчлийг арилгасан.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн агуулга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:											
2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	2021 оны жилийн Завсрын аудитаар хяналтын тооллогоор үндсэн хөрөнгө биетээр байхгүй дутагдсан.	1	523.7	1	523.7						
2	Завсрын аудитаар тээвэр шатахууны зардлыг өглөгөөр тусгаагүйг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй.	1	46,576.7					1	46,576.7		
	Нийт зөрчлийн дүн	2	47,100.4	1	523.7	-	-	1	46,576.7		